



ТӨВ АЙМАГ  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 25 өдөр

Дугаар А/47

Зуунмод


Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 65 дугаар зүйлийн 65.1.1, Нийгээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрийн тухай хуулийн 4.1.3, 6.3, Ахмад настны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, Байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмын 7 дугаар зүйлийн 12 дахь заалтын “а”-г үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. ХҮП жарны “Усан бар” жилийн сар шинийн баярыг тохиолдуулан тус аймгийн Засаг даргаар олон жил ажиллаж байсан ахмадууд болон Гандантэгчилэн хийдэд сар шинийн шүүс, идээгээр хүндэтгэл үзүүлэх зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

2. Дээрх зардалд шаардагдах 3,322,500 (гурван сая гурван зуун хорин хоёр мянга таван зуу) төгрөгийг Хуваарилагдаагүй зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ю.Бямбацогт)-г, зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (С.Магнайбаяр)-д тус тус зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

Санхүүжүүлж.

*(Handwritten signature)*

25/5

Аймгийн Засаг даргын 2022 оны  
01 -р сарын 25 -ны өдрийн  
А/НЗ -р захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	Ууцлах хонины мах	ш	5	300,000	1,500,000
2	Ууцлах хонинын мах /Төв гандан УБ/	ш	1	350,000	350,000
3	Гандан хийдэд аймаг орон нутаг, ард иргэдээ даатгаж засал ном уншуулах	ш	1	1,000,000	1,000,000
4	Хадаг	ш	5	4,000	20,000
5	Хадаг /том/	ш	1	15,000	15,000
6	Сүү	Хайрцаг	10	3,000	30,000
7	Шар тос	кг	3	28,000	84,000
8	Ааруул	кг	3	22,000	66,000
9	Өрөм	Тогооны	1	22,000	22,000
10	Бяслаг	кг	2	20,000	40,000
11	Боорцог	кг	10	3,000	30,000
12	Еэвэн /Суурь/	ш	1	20,000	20,000
13	Ууц чанах хөлс /мод, нүүрс/	ш	1	30,000	30,000
14	Элсэн чихэр	кг	10	3,000	30,000
15	Цагаан будаа	кг	25	3,100	77,500
16	Ёотон	Хайрцаг	2	4,000	8,000
	Дүн				3,322,500

ТӨСӨВ ГАРГАСАН:  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАНЫ ДАРГА



Э.БАЯРБАТ

ХЯНАСАН:  
ТӨСВИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Ч.ЦЭЦЭГСҮРЭН

ХАМГААГАХ  
ТӨСВИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН